

“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын даргын
2025 онысарын.....өдрийнтушаал

Арван гурав. Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах

13.1 Үйлдвэрийн газрын зорилтыг биелүүлэхийн хүрээнд шаардлагатай ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор мэргэжил, ур чадвар эзэмшсэн иргэнийг ажилд авахдаа холбогдох баримт бичгийг үндэслэн, үнэнч шударга байдал, мэргэжлийн дадлага туршлага, эзэмшсэн мэдлэг чадвар, эрүүл мэнд, сахилга бат зэргийг харгалзан хүний нөөцийг бүрдүүлнэ.

13.2 Ажилтныг сонгон шалгаруулахдаа дараах шатаар шалгаруулна.

13.2.1 Анкетны сонгон шалгаруулалт

13.2.2 Анхан шатны ярилцлага / Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн, Архивч, хүний нөөцийн ажилтан /

13.2.3 Дараагийн шатны ярилцлагыг харъяалах Хэлтсийн дарга болон Захиргаа, удирдлага, хүний нөөцийн хэлтсийн дарга хийнэ.

13.3 Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэн дор дурьдсан бичиг баримт, материалыг бүрдүүлнэ. Үүнд:

13.3.1 Ажилд орохыг хүссэн өргөдөл

13.3.2 Анкет

13.3.3 Цээж зураг $\frac{3}{4}$ хэмжээтэй 6 хувь / сүүлийн 6 сарын дотор авахуулсан/

13.3.4 Боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээний хуулбар/ нотариатаар батлуулах /

13.3.5 Иргэний оршин суугаа хаягийн бүртгэлийн лавлагаа

13.3.6 Эрүүл мэндийн үзлэгийн хуудас

13.3.7 Өмнө ажиллаж байсан ажлын газрын тодорхойлолт

13.3.8 Гурван үеийн намтар

13.3.9 Урьд эрхэлж байсан ажлас чөлөөлөгдсөн тушаалын хуулбар

13.3.10 Жолоочийн хариуцлагын даатгалд 1 жилээр хамрагдсан талаарх баримт

13.3.11. Жолоодох эрхийн лавлагаа / 1 сарын дотор хүчинтэйд тооцно.

13.3.12 Иргэний жолооны болон мэргэшсэний үнэмлэхний хуулбар